



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ”
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар Б/03

Бор-Өндөр сум

Д.Хүрэлбатыг гал тогооны туслах
ажилтнаар томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дамбаагийн Хүрэлбатыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн гал тогооны туслах ажилтны албан тушаалд томилсугай.

2. Д.Хүрэлбатын албан тушаалын үндсэн цалинг ТҮ-1 зэрэглэл 954,000 (есөн зуун тавин дөрвөн мянга) төгрөгөөр тогтоож, хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн нэмэгдэл хөлс олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн ажиллахыг гал тогооны туслах ажилтан (Д.Хүрэлбат)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.АМАРЖАРГАЛ